

Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд хандаж гаргасан  
өргөдөл, гомдол саналын шийдвэрлэлтийн мэдээ  
/2021 оны 3 дугаар улирлын байдлаар/

2021.10.01

Арвайхээр

Иргэд, аж ахуй нэгж, байгууллагаас аймаг, сумдын Засаг даргын Тамгын газар болон Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төсөвт байгууллагад 2021 оны 3 дугаар улирлын байдлаар нийт 14523 өргөдөл, гомдол, санал ирүүлсэн байна. Үүнээс өргөдөл 13198 буюу 75.2 хувь, гомдол 512 буюу 9.4 хувь, санал 840 буюу 15.9 хувийг тус тус эзэлж байна.

Аймгийн хэмжээнд нийт 14523 өргөдөл, гомдол, санал ирсний 14211 буюу 97.85 хувь нь шийдвэрлэгдсэн, 1938 буюу 13.34 хувь нь бусад байгууллагад шилжүүлж хариуг хүргүүлсэн, 312 буюу 2.1 хувь нь шийдвэрлэх хугацаа болоогүй байна. Хуулийн хугацаа хоцроож хариу хүргүүлсэн өргөдөл, гомдол, санал 13 буюу 0.1 хувийг эзэлж байна.

Иргэд, аж ахуй нэгж, байгууллагаас төрийн байгууллага, албан тушаалтанд хандаж гаргасан өргөдөл, гомдол саналыг бусад байгууллагад шилжүүлсэн 1938 буюу 13.34 хувь байх бөгөөд үүнээс 1096 буюу 56.6 хувь нь “Үйлчилгээний нэгдсэн төв 7032-1111” төвд хандаж гаргасан байна. Тус 1096 өргөдөл гомдол саналын 671 буюу 61 хувь нь төрийн үйлчилгээтэй холбоотой мэдээлэл, тодруулга авахыг хүссэн иргэдийн дуудлага байна.

2021 оны 3 дугаар улирлын байдлаар аймгийн Засаг даргад хандаж тусламж хүсэж өргөдөл ирүүлсэн 52 иргэнд 26.5 сая төгрөгийн нэг удаагийн буцалтгүй мөнгөн тусламж үзүүллээ.

Хуралдааны тэмдэглэлийг хавсаргав.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

## ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

### СУМЫН ЗАСАГ ДАРГА, АГЕНТЛАГИЙН ДАРГА НАРТ

Аймгийн Засаг даргын Зөвлөлийн 2021 оны 09 дугаар сарын 27-ны өдрийн хурлын 12 дүгээр тэмдэглэлд:

2021 оны 3 дугаар улирлын байдлаар “Иргэд, аж ахуй нэгж, байгууллагаас төрийн байгууллага, албан тушаалтанд хандаж ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлт”-ийн мэдээг аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга гишүүдэд танилцуулав.

Үүнтэй холбогдуулан сумын Засаг дарга, агентлагийн дарга нарт даалгав.

1. Өргөдөл, гомдол, саналын шийдвэрлэлтийн мэдээг улирал бүр сум агентлагууд өссөн дүнгээр ирүүлэх бөгөөд тухайн улиралд гомдлын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээг тайлан хэлбэрээр ирүүлж байх

2. Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлыг шийдвэрлэх тухай хуульд заасан хугацаа хоцроосон өргөдөл гомдол санал 13 гарсан байх бөгөөд цаашид хуулийн хугацаа хоцроохгүй байх тал дээр сум, агентлагууд анхаарч ажиллах

3. Бусад байгууллагад шилжүүлсэн өргөдөл гомдол саналын шийдвэрлэлтийн байдалд дүгнэлт хийж улирлын мэдээнд тусгаж байх

4. Тухайн улирлын байдлаар иргэд, аж ахуй нэгж, байгууллагаас төрийн байгууллага, албан тушаалтанд хандаж гаргасан өргөдөл, гомдол саналын шийдвэрлэлтийн мэдээг сум, агентлагууд байгууллагын самбар, цахим хаягт байрлуулж хэвшихэд хяналт тавьж ажиллахыг Сум, багийн асуудал хариуцсан мэргэжилтэн Б.Сайнбилэгт даалгав.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

ИРГЭДЭЭС ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА, АЛБАН ТУШААЛТАНД ХАНДАЖ  
ИРҮҮЛСЭН ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ, САНАЛЫН ШИЙДВЭРЛЭЛТИЙН БАЙДАЛ /НЭГТГЭЛ/

2021.10.01

Арвайхээр

д/д	Байгууллагын нэр	Нийт өргөдөл, гомдол саналын тоо	Шийдвэрлэлт			Хугацаа болоогүй	Шийдвэрлэлт
			Шийдвэрлэж хариу өгсөн	Бусад байгууллагад шилжүүлсэн	Хугацаа хэтэрсэн		/Хувь/
1	Аймгийн засаг даргын Тамгын газар	214	190	118	0	24	88.8
2	Үйлчилгээний нэгдсэн төв /7032-1111/	1096	1096	1096	3	0	100.0
3	Агентлаг	1590	1476	19	10	114	92.8
4	Сумд	11623	11449	705	0	174	98.5
	Дүн	14523	14211	1938	13	312	97.9
	Хувь	100.0	97.85	13.34	0.1	2.15	

ИРГЭДЭЭС ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА, АЛБАН ТУШААЛТАНД  
ХАНДАЖ ИРҮҮЛСЭН ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ, САНАЛ /ХЭЛБЭРЭЭР/

2021.10.01

Арвайхээр

д/д	Байгууллагын нэр	Нийт ирсэн өргөдөл, гомдол, санал	Үүнээс:				
			Бичгээр	Цахимаар	Утсаар	Биечлэн	Бусад
1	Аймгийн засаг даргын Тамгын газар	214	214	0	0	0	0
2	Агентлаг	1586	1531	18	22	15	0
3	Сум	11623	9792	716	546	484	89
4	Үйлчилгээний нэгдсэн төв /7032-1111/	1096	5	0	1091	0	0
	Дүн	14523	11542	734	1659	499	89
		100.0	79.6	5.0	11.4	3.4	0.6

## ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ, САНАЛЫН АГУУЛГА /ХУВИАР/

2021.10.01

Арвайхээр

Аймгийн нэр	/тоо, нийт өргөдөл, гомдол саналд эзлэх хувь/			
Өвөрхангай аймаг	Нийт өргөдөл, гомдол, санал 14523 ирсэн байна.	хүсэлт	13198	75.17%
		гомдол	512	9.36%
		санал	840	15.90%
	Нийгмийн халамжийн үйлчилгээ	3566	24.6%	
	Иргэний бүртгэл, мэдээлэл	1486	10.2%	
	Газар эзэмших, өмчлөх, шилжүүлэх	1238	8.5%	
	Ажилд орох, чөлөөлүүлэх	1185	8.2%	
	Тэтгэвэр тогтоолгох, тэтгэмж хүссэн	844	5.8%	
	Хөдөлмөр эрхлэлт	208	1.4%	
	Материал, мөнгөн тусламж хүссэн	264	1.8%	
	Шилжилт хөдөлгөөн	306	2.1%	
	Сургууль курст суралцах	48	0.3%	
	Нийгмийн даатгал	2187	15.0%	
	Бусад	3079	21.2%	
- Аймгийн “Үйлчилгээний нэгдсэн төв”-ийн 70321111 дугаарын утсанд нийт 1096 өргөдөл, гомдол, санал хүсэлт ирсэнээс 1093 буюу 99.7 хувийг хуулийн хугацаанд шийдвэрлэж хариу өгсөн байна.				

